| 89 | ЗДЗАХХА ХТ-3.4.3.4 | Жаргалтай амьдрал төв байгуулж үйл ажиллагааг эрчимжүүлнэ. | 2024 | АЗДТГ, ХХҮГ, ЦГ | ОНТ | 167.0 | тоо | 2022 | 20 | 22 | 167.0 | | Төв аймгийн Баян сум дахь "Архины албадан эмчилгээний төв"-д 10 иргэнийг, архины архаг хэрэглээтэй болон орон гэргүй тэнэмэл иргэдийг нийгэмшүүлэх ажлын хүрээнд "Жаргалтай амьдралын төв"-д 134 иргэнийг, Нэгдсэн эмнэлгийн Сэтгэц наркологийн тасгийн сайн дурын эмчилгээнд 216, нийт 360 иргэн хамруулсан.Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх саатуулах байр, Эрүүл мэндийн газар, бусад төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран эрүүлжүүлэгдсэн болон баривчлагдсан иргэдэд 180 удаа, давхардсан тоогоор эрүүлжүүлэгдсэн 183, саатуулагдсан 202, баривчлагдсан 1432 иргэнд 520 цагийн албадан сургалтыг зохион байгууллаа. "Жаргалтай амьдрал төв"-ийн 2024 оны үйл ажиллагааны зардал 138.6 сая төгрөгийг аймгийн ГХУСАЗСЗ-ийн төсөвт тусган санхүүжүүллээ. **Үр дүн: Архины сайн дурын болон албадан эмчилгээнд 360 иргэнийг хамрууллаа.** | 100% |
| | **Салбарын үр дүн:** Усны нөөц, чанарын хяналтыг сайжруулж, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах, зөв зохистой ашиглах менежментийг хэрэгжүүлнэ. | | | | | | | | | | | | | |
| 90 | ЗДҮАХХА ХТ-4.1.1.1 | Булаг шандын эхийг хашиж хамгаалах | 2024 | БОАЖГ, СДОА | БОХНСАХЗ | 50.0 | тоо | 2022 | 0 | 4 | 50.0 | | Булаг шанд тохижуулах ажлыг 2024 онд Хонгор сумын 2 багийн нутаг Хурагтын амны булгийг Монголын эмэгтэйчүүдийн манлайлал сан төслөөс санхүүжүүлэн Дархан сумын ахмадын хорооны эмэгтэй манлайлал ТТБайгууллага, Хар бэлчрийн ар булгийг Дархан дулааны цахилгаан станц ТӨХК нь Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд дэмжлэг үзүүлж тохижилтын ажлыг хамтран зохион байгуулж ажилласан. **Үр дүн: 2 булаг шандын эхийг хашиж** | 70% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | **тохижуулсан** | |
| 91 | | Хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсэд хамгаалалтын хайс барьж тохижуулах | 2024 | БОАЖГ, СДОА | БОХ НСА ХЗ | 24.0 | тоо | 2022 | 0 | 3 | 24.0 | 0.0 | Дархан хотын хүн амын ус хангамжийн төв өндрийн цамхгийг ариутгах ажлыг Дархан Ус суваг ХК хийж гүйцэтгэсэн. Ундны усны эх үүсвэрийг хайс барьж тохижуулах ажлын зураг төсөв боловсруулагдсан. Нийт төсөвт өртөг 1.9 тэрбум төгрөг. Хөрөнгийн эх үүсвэрийг 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэхээр саналыг Барилга хот байгуулалтын яаманд цахим систем /PIMIS/ хүргүүлсэн.<br>**Үр дүн: Хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсэд хамгаалалтын хайс барьж тохижуулах ажлын зураг, төсөв боловсруулагдсан**. | 30% |
| 92 | | Гадаргын усны чанарын шинжилгээний болон хэмжилтийн явуулын багаж, тоног төхөөрөмж авах | 2024 | БОАЖГ, СДОА | БОХ НСА ХЗ | 10.0 | тоо | 2022 | 0 | 4 | 10.0 | 0.0 | Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. | 0% |
| 93 | ЗДҮАХХА ХТ-4.1.2.1 | Уул уурхай болон бусад үйл ажиллагаанаас эвдэрч эзэнгүй орхигдсон 4га газарт нөхөн сэргээлт хийх | 2024 | БОАЖГ, СДОА | БОХ НСА ХЗ | 120, 000. 0 | га | 2022 | 2 | 4 | 120,00 0.0 | | БОАЖЯамны сайдын Б.Бат-Эрдэнэ дэмжлэгтэйгээр “Оюу толгой ХХК”-тай 2023 оны 12 сард тус аймгийн Хонгор сумын нутагт орших Их ноёны ам, Бага ноёны ам, Хургадын ам, Шарын гол сумын нутагт орших Цагаан хөтөл орчмын 4 байршилд нийт 215.5 га газарт техникийн нөхөн сэргээлт хийх тухай гэрээ байгуулж 2024 онд Хонгор, Шарын гол сумын нутагт 4 байршилд нийт 215,5 га газарт техникийн нөхөн сэргээлт хийгдэх ажил гүйцэтгэсэн. Тус нөхөн сэргээлтийн ажлыг “Бугант нандин” ХХК 91,6 га, “Дархан-Транс” ХХК 123,92 га хийж 100 хувийн гүйцэтгэлтэйгээр орон нутагт актаар хүлээлгэн өгч, эвдэрсэн газрын цахим санд оруулсан<br>Цаашид нөхөн сэргээлт хийсэн талбайг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах ажлыг зохион байгуулахыг сумдын Засаг даргын Тамгын газарт чиглэл хүргүүлсэн.<br>Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 10 аж ахуйн нэгжүүдийн техникийн 52,2 га, биологийн 10,5 га, дүйцүүлэн хамгааллаар 10,25 га, нийт 72,95 га газрын нөхөн сэргээлтийг актаар хүлээн авсан.<br>**Үр дүн: 215.5га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн.** | 100% |
| 94 | ЗДҮАХХА ХТ-4.1.2.2 | Уул уурхай, ашигт малтмалын ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтэд хяналт тавих болон хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх | 2024 | БОАЖГ, СДОА | БОХ НСА ХЗ | 8.1 | тоо | 2022 | 8 | 10 | 8.1 | 8.1 | 2024 оны Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хууль бус олборлолттой тэмцэх, нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу БОГ, ЦГ, Хонгор, Шарын гол сумдын ЗДТГ-уудтай хамтран 10 удаагийн нэгдсэн хяналт шалгалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 64 | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | албан хаагч ажилласан.Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг үйлдэгдэх өндөр эрсдэл бүхий газруудыг хамгаалах зорилгоор 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн №01-А/131 дугаартай Дархан-Уул аймгийн Засаг даргын захирамжийн дагуу Дархан-Уул аймгийн ойн болон усан сан газарт зорчих автозамын гол зангилаа газруудад 2024 оны 04 дүгээр сарын 01 ний өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл 24 цагийн байнгын үйл ажиллагаатай 3 постуудыг гарган ажиллуулсан.<br>**Үр дүн: Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг гараагүй.** | |
| 95 | ЗДҮАХХА ХТ-4.1.2.3 | Шилмүүст модны ойжуулалтыг 20га талбайд хийнэ. | 2024 | БОАЖГ, СДОА | БОХ НСА ХЗ | 24.0 | га | 2022 | 10 | 20 | 24.0 | 24.0 | Орон нутгийн төсвийн 12,0 сая.төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хонгор сумын Мөөл ууланд 10 га талбайд шинэс, нарс модны 25000 ширхэг тарьцаар ойжуулалтын ажлыг Алд дэлгэм ХХК гүйцэтгэсэн.<br>**Үр дүн: 10га талбайд ойжуулалтын ажил хийгдсэн.** | 70% |
| 96 | ЗДҮАХХА ХТ-4.1.2.3 | Навчит модны ойжуулалтыг 20га талбайд хийнэ. | 2024 | БОАЖГ, СДОА | БОХ НСА ХЗ | 57.0 | га | 2022 | 10 | 20 | 57.0 | 1,500.0 | 2024 онд доройтсон ойг нөхөн сэргээх чиглэлээр 50 га талбайд 114724 ширхэг, цөлжилт, газрын доройтлыг бууруулах, голын татмыг нөхөн сэргээх, авто зам, тариалангийн талбай хамгаалах ойн зурвас байгуулах чиглэлээр 2 га, 41 км хамгаалалтын зурваст 130271 ширхэг, хот суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд 775433 ширхэг, 16000 м2 талбайг зүлэгжүүлж, жимсний болон агро аж ахуйг хөгжүүлэхэд 43500 ширхэг нийт 366038 ширхэг мод бут тарих ажилд 4693 иргэн, 154 аж ахуйн нэгж, байгууллага оролцож, улс, орон нутгийн төсөв, аж ахуйн нэгжийн нийт 1,5 тэрбум.төгрөг зарцуулсан дүнтэй байна.<br>**Үр дүн: Навчит модны ойжуулалтыг 52 га талбайд хийсэн.** | 100% |
| 97 | ЗДҮАХХА ХТ-4.1.2.4 | Ойн зурвас байгуулах төсөл | 2024 | БОАЖГ, СДОА | БОХ НСА ХЗ | 45.0 | га | 2022 | 4 | 4 | 45.0 | 22.5 | Орхон сумын нутагт 2 га талбайд ойн зурвас байгуулах ажлыг орон нутгийн төсвийн 22,5 сая.төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Ногоон тураглиг" ХХК гүйцэтгэж хайлаас, шар хуайс, тэхийн шээг, монос төрлийн 1800 ширхэг навчит модыг тарьж, хашаажуулалтыг хийж гүйцэтгэсэн. Амьдралтын хувь 75 хүрээгүй тул 2024 оны намрын тарилтаар гүйцэтгэсэн модыг 2025 онд хүлээж авахаар шийдвэрлэсэн.<br>**Үр дүн: Ойн зурвас байгуулах ажлыг 2га талбайд хийсэн.** | 70% |
| 98 | ЗДҮАХХА ХТ-4.1.4.2 | Ойн хөнөөлт шавжтай тэмцэх төсөл | 2024 | БОАЖГ, СДОА | БОХ НСА ХЗ | 40.0 | га | 2022 | 2000 | 1000 | 40.0 | | "Ойн хайгуул" ХХК-тай механик аргаар тэмцлийн ажлыг орон нутгийн төсвийн 16,0 сая.төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хонгор сумын 2 дугаар багийн нутаг Хүйтний голын ойн санд тархсан 500 га талбайд гэрлэн урхи ашиглан явуулсан. Ажлын | |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 99 | | Ойн хөнөөлт шавжтай гэрлэн урхи, дэлгэц тавих механик аргаар тэмцлийн ажил явуулах | 2024 | БОАЖГ, СДОА | БОХ НСА ХЗ | 16.0 | га | 2022 | 0 | 500 | 16.0 | 16.0 | даалгаврын дагуу тайлан, ажлын гүйцэтгэлийн актаар 520 гр ширхгээр тооцвол 2600 орчим эрвээхэй цуглуулж устган эдийн засгийн үр ашгийг тооцож гаргасан.<br>**Үр дүн: 500га талбайд хөнөөлт шавжтай тэмцэх ажил хийгдсэн.** | 100% |
| | **Салбарын үр дүн**: Хөрөнгө оруулалтыг дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлэн, орон нутгийн хөгжлийн таатай орчныг бүрдүүлнэ | | | | | | | | | | | | | |
| 100 | ЗДҮАХХА ХТ-5.1.1.1 | Хар металлургийн үйлдвэрийн цогцолбор, Барилга, барилгын материалын үйлдвэрийн цогцолбор, Дархан арьс ширний үйлдвэрийн цогцолбор, Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ | 2024 | АЗДТГ, ХБТХОХ, ХХААГ | Бусад | | | | | | | | 1. Дархан арьс ширний цогцолбор ХХК үйлдвэрийг байгуулснаар 7500 орчим байнгын ажлын байр, жилдээ 10 сая.ш арьс шир боловсруулах 13 үйлдвэр, 10 мян.тн ноос боловсруулах ноос, ноолуур угаах самнах үйлдвэр, түүний цэвэрлэх байгууламж, инженерийн дэд бүтцийн барилга байгууламж бий болох бөгөөд 2024 оныг хүртэл төслийн нийт төсөвт өртгийн 47.4 хувийг гүйцэтгэсэн. "Дархан Арьс Ширний Цогцолборын бүтээн байгуулалт" ТӨХК-д орон нутгаас арьс ширний цогцолбор барих ажилд 25 га талбайг шийдвэрлэсэн.<br>2. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчээр 60 аж ахуйн нэгж, 23 иргэн бүртгэлтэй байна. Салбараар нийт 97 үйлдвэр, цех үйл ажиллагаа явуулж байна. Хүнсний хувьсгалын хүрээнд арилжааны банкаар дамжуулан олгосон эргэлтийн болон хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээлд 2023 онд 44.52 тэрбум төгрөг, 2024 онд 1 мал төхөөрөх үйлдвэрт 3.0 тэрбум төгрөгийн, ЖДҮХС-ийн зээлээс 2023 онд 6 аж ахуйн нэгжид 716 сая төгрөг, 2024 онд 9 аж ахуйн нэгжид 1.42 тэрбум төгрөгийн дэмжлэг тус тус үзүүлсэн. Хөнгөлөлттэй зээлд хамруулснаар ажлын байр, агуулахыг стандартад нийцүүлж, техник, технологийн шинэчлэл хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлж өгсөн.<br>**Үр дүн: Хүнсний боловсруулах үйлдвэрт 1129 хүн тогтвортой ажиллаж байна**. | 50% |
| 101 | ЗДҮАХХА ХТ-5.1.1.2 | Хөрөнгө оруулалтын чуулган зохион байгуулах | | АЗДТГ | ОНТ, Найрамдал төсөл | 10.0 | тоо | 2022 | 2 | 2 | 10.0 | 10.0 | Төвийн бүсийн хөгжлийн чуулган шинэ стандарт чуулганыг ЗГХЭГ, Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн, Дархан-Уул аймгийн ЗДТГ-тай хамтран 2024оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Дархан-Уул аймагт зохион байгуулсан. Уг арга хэмжээнд Төв, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагууд, олон улсын байгууллага, эрдэмтэд, төр, хувийн хэвшил, иргэд олон нийт зэрэг 2000 орчим төлөөлөл оролцсон. Арга хэмжээний үр дүнд гарааны бизнес, инновацын шинэлэг санаануудыг цааш нь хөгжүүлэх нөөц боломжийг нээж, хөрөнгө оруулагч нартай холбоо тогтоох, Дархан хотод байрлах инновац, энтрепренершип, гарааны компанийг бойжуулах ажлыг эрчимжүүлэх шийдвэрүүд гарсан.<br>**Үр дүн: Хөрөнгө оруулалтын чуулган зохион** | 100% |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | **байгуулсан.** | |
| 102 | ЗДҮАХХА ХТ-5.1.2.1 | Дархан сумын 5 дугаар багийн гэр хорооллыг хувийн орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ. | 2024 | АЗДТГ, "ДДТ" ОНӨАА ТҮГ | Бус ад | 0 | тоо | 2022 | 0 | 35 | 0 | 0.0 | 1. Дархан дахин төлөвлөлт ОНӨААТҮГ нь Дархан-Уул аймагт хэрэгжиж буй Европын хотуудын холбооны санхүүжилттэй Найрамдал төслийн хүрээнд Дархан сумын 5 дугаар багийн гэр хорооллын нутаг дэвсгэрт хийгдсэн гадна инженерийн шугам сүлжээнээс хэрэглэгчийг холбох 2 дугаар хэлхээний шугам сүлжээний зургийг нэгдсэн байдлаар хийж гүйцэтгэсэн. Тус байршилд 289 айл өрхийн шугам сүлжээний зураг төсөв хийгдсэн.<br>**Үр дүн: Гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн дэд бүтцэд холбох ажлын зураг, төсөв боловсруулагдсан.** | 30% |
| 103 | ЗДҮАХХА ХТ-5.1.2.3 | Дархан сумын 7 дугаар багийн зарим хэсэг, 8 дугаар багийн гэр хорооллыг хувийн орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ. | 2024 | АЗДТГ, "ДДТ" ОНӨАА ТҮГ | Бус ад | 0 | тоо | 2022 | 25 | 45 | 0 | 624.0 | 1. Дархан дахин төлөвлөлт ОНӨААТҮГ нь Дархан-Уул аймагт хэрэгжиж буй Европын хотуудын холбооны санхүүжилттэй Найрамдал төслийн хүрээнд Дархан сумын 8 дугаар багийн Нарантолгой, Манхантолгой гэр хорооллын нутаг дэвсгэрт хийгдсэн гадна инженерийн шугам сүлжээнээс хэрэглэгчийг холбох 2 дугаар хэлхээний шугам сүлжээний зургийг нэгдсэн байдлаар хийж гүйцэтгэсэн. Тус байршилд 298 айл өрхийн шугам сүлжээний зураг төсөв хийгдсэн.<br>2. Дархан сумын Манхантолгой хэсгийн 38 айл өрхийн дулааны техникийн нөхцөлийн хүсэлтийг нэгтгэж Дархан дулааны сүлжээ ТӨХК-р хэлэлцүүлэн 35 айлд дулааны техникийн нөхцөлийг гаргуулах ажлыг зохион байгуулсан.<br>3. 2024 оны Эдийн засаг, хөгжлийн сайдын А/12 дугаар тушаалаар батлагдсан Дархан сумын 1,3,5,6,7,8,9,14,15 дугаар багийн гэр хорооллын нутаг дэвсгэрт хийгдэж буй Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байна.<br>**Үр дүн: Дархан сумын 1, 3, 5, 6, 7, 8, 9, 14, 15 дугаар багийн гэр хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдаж байна.** | 30% |
| | **Салбарын үр дүн :** Түүхий эдийн нөөцөд тулгуурлан, орон нутгийн онцлогт тохирсон эдийн засгийн өсөлтийг дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | | | | | | | | | | | | | |
| 104 | ЗДҮАХХА ХТ-5.1.3.1 | Паркийн гишүүн аж ахуйн нэгжийг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжих | 2024 | ДҮТП, ХОХБТ Х | ОНТ, Найрамдал төсөл | 200.0 | тоо | 2022 | | 10 | 200.0 | | 2021 онд Австри улсын Засгийн газрын 1 сая еврогийн санхүүжилтээр аймгийн гэр хорооллын гудамж талбайд сүүлийн үеийн лед гэрэлтүүлэг шинээр суурилуулах ажлыг Дархан сумын 1, 2, 3, 5, 6, 7, 8, 13, 15 дугаар баг, Хонгор, Орхон, Шарын гол сумдад нийт 1,408.0 ширхэг гэрэлтүүлэг шинээр суурилуулах ажил хийгдсэн. Азийн Хөгжлийн Банкны хөнгөлөлттэй зээлээр "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хөгжлийн төв"-ийг Дархан сумын 12 дугаар багт шинээр байгуулсан. 2022 онд Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламж "Өвсний үндэс" төслийн хүрээнд Дархан сумын "Энэрэл" сургуулийн барилгын их засварын ажлыг 600.0 сая төгрөгөөр, Дархан сумын 5-р баг 15-р сургуулийн барилгын 00 засвар, 12-р сургуулийн 00 засварын ажлыг 300.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн бол Дархан сумын 15- | ҮБ/ХБ |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | р багт 960 хүүхдийн сургуулийн барилгыг Азийн хөгжлийн банкны хөнгөлттэй зээлийн хөрөнгөөр 10.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдаж байна. 2023 онд Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг иргэд олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд цахим орчинд болон иргэд олон нийтэд 3 удаагийн уулзалтыг 4 сумын хэмжээнд /бүх сумдад/ зохион байгуулсан. Аймгийн ИТХ-ын хуралдаанд 2023 оны 4, 7-р сард аймаг орон нутагт хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээг танилцуулж, мэдээллээр хангаж ажиллаа. Хөрөнгө оруулалтын чуулга уулзалтыг 2023 оны 7-р сард Найрамдал төсөлтэй хамтран зохион байгуулсан. **Үр дүн: Гадаадын зээл тусламжаар 2021-2024 онд нийт 22.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн.** | - |
| 105 | ЗДҮАХХА ХТ-5.1.3.2 | Арьс ширний цогцолборын бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлнэ. | 2024 | ДҮТП, ХОХБТХ, ХХААГ | Бус ад | 150,000.0 | Хувь | 2022 | 20 | 60 | 150,000.0 | | 1.Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй "Дархан арьс ширний цогцолбор ХХК" үйлдвэрийн эрчим хүч, усан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламж, дулаан хангамж, уурын зуух зэргийг барьж байгуулахад 15.4 сая ам долларын хөрөнгө оруулалтыг хийж, эрчим хүч 95%, дэд станц ажил гүйцэтгэл 90%, ус, дулаан хангамж 70%, бохир ус цэвэрлэх байгууламжийн аэро-танк зэрэг ажлууд хийгдсэн. Төслийн нийт төсөв өртөг нь 86.2 тэрбум төгрөг үүнээс 40.8 тэрбум төгрөгийн ажил хийгдэж 47.4 хувийн гүйцэтгэлтэй ажиллажээ. 2024 онд Дархан-Уул аймгийн Засаг дарга Б.Азжаргал, ХХААХҮЯ-ны сайд Ж.Энхбаяр болон "Дархан арьс ширний цогцолбор" ХХК-ий гүйцэтгэх захирал Д.Энхбаяр болон холбогдох албаны төлөөлөлтэй уулзаж, хувийн хэвшлийн тулгамдаж буй асуудлыг сонсож, цаашид үйл ажиллагааг нь эрчимжүүлэх тал дээр санал солилцсон.<br>2.Монгол Улсын Засгийн газрын 2020-2024оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссаны дагуу 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн Засгийн газрын 185 дугаар тогтоолоор "Дархан арьс ширний цогцолбор" төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил, эзэмшил, ашиглалтыг хариуцах "Дархан Арьс Ширний Цогцолборын бүтээн байгуулалт" ТӨХК-г байгуулагдсан. Орон нутгаас арьс ширний цогцолбор барих ажилд 25 га талбайг шийдвэрлэсэн.<br>**Үр дүн: Орон нутгаас бодлогоор дэмжин газар олголтыг шийдвэрлэсэн.** | 0% |
| 106 | ЗДҮАХХА ХТ-5.1.3.3 | Мах сүүний аж ахуйд өндөр технологийг нутагшуулах, мах-сүү үйлдвэрлэлийн өсөлтийг хурдасгахад дэмжлэг үзүүлэх | 2024 | ХХААХҮЯ МУСҮТөв, АЗДТГазар, төсөл хөтөлбөрүүд | Бус ад | | | | | | | | Аймгийн хэмжээнд үхэр сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах зорилгоор Малын удмын сангийн үндэсний төвтэй хамтран 2 мал үржүүлгийн техникч 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Шарын гол, Хонгор, Орхон сумдын 2 аж ахуйн нэгж, 21 малчин өрхийн 230 үнээнд зохиомол хээлтүүлэг хийсэн.<br>Шарын гол, Орхон, Хонгор сумын хэмжээнд түүврийн аргаар нийт 1 ААН, 6 малчин өрхийн нийт 61 үнээнд хээл тодорхойлох үзлэг хийхэд 41 нь хээлтэй, 20 нь хээлгүй, үнээний хээл авалт 67.2%-тай байгаа нь өмнөх оныхоос 8.8%-иар өссөн | 100% |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | дүнтэй байна.<br>**Үр дүн: Шарын гол, Орхон, Хонгор суманд хээлт тодорхойлох үзлэг хийхэд өмнөх оноос 8.8%-иар өссөн.** | |
| 107 | ЗДҮАХХА ХТ-5.1.3.4 | Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний гарц хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 2024 | ХОХБТ Х, ХХААГ, ГХБХБГ | ОНТ | 30.0 | тоо | 2022 | 2 | 4 | 30.0 | 0,0 | Дархан-Уул аймагт 2023 оны байдлаар БМҮ 35 аж ахуйн нэгж байгуулга 8 үйлдвэрлэлийн чиглэлээр тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж байсан. 2024 онд 4 аж ахуйн нэгж байгуулга тусгай зөвшөөрөл шинээр авч барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний гарц хүртээмжийг нэмэгдүүлж ажилласан. | 100% |
| 108 | ЗДҮАХХА ХТ-5.1.3.5 | Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийг дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих | 2024 | ХХААГ | УТХО | 400.0 | тоо | 2022 | 1 | 5 | 400.0 | 200.0 | Хүнсний ногоо, боловсруулах, нөөшлөх, савлах хоногт 7.0-8.0 тонны хүчин чадалтай 8 цех /төмс, хүнсний ногоо угааж, ангилан савлах аж ахуйн нэгж 6, иргэн 2/, үйлдвэрлэлт нь дунджаар жилд 5.4 тонн байна. Ажилчдын тоо 46. Улаанбаатар хотын хүнсний ногоо боловсруулах 4 үйлдвэр Орхон суманд түүхий эд хүлээн авах цэгийг байршуулж, Орхон сумын тариаланчидтай гэрээ байгуулж, захиалгаар хүнсний ногооны тариалалтыг гүйцэтгүүлэн, зориулалтын тээврийн хэрэгслээр татан авч байна.Ургамлын цай, хужир, эмийн ургамал, бэлдмэлийн 1 аж ахуйн нэгжийн хүчин чадал хоногт 3.0 тонн, байгалийн ургамлын ургац, төрлөөс хамаарч жилд 1.0-1.5 тонн цай савладаг. 2024 онд ЖДҮХС-ийн хөнгөлөлттэй зээлээс 300.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Жимс, жимсгэнэ боловсруулах үйлдвэр 2, хүчин чадал хоногт 2.2 тонн, ажилчдын тоо 4 байна.<br>**Үр дүн: 2024 онд 3 аж ахуйн нэгжид ЖДҮХС-ийн хөнгөлөлттэй зээлээс 500.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.** | 100% |

ТАНИЛЦСАН:

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ

ДАРГА Б.АЗЖАРГАЛ

ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАСАН:

ХБТХОХ-ИЙН ДАРГА П.БАТСҮХ

ХЭРЭГЖИЛТ НЭГТГЭЖ, БОЛОВСРУУЛСАН

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГЧ Б.БАТСҮХ

## ДАРХАН-УУЛ АЙМГИЙГ 2024 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА /арга хэмжээгээр/

2024.12.13 Дархан-Уул аймаг

| № | Хяналтад авсан бодлого / Арга хэмжээний үнэлгээ | | | Бүгд |
|---|---|---|---|---|
| 1. | Хяналтанд авсан салбарын тоо | | | **17** |
| 2. | Хяналтанд авсан төсөл, арга хэмжээний тоо | | | **108** |
| 3. | Үнээс | Үр дүнтэй буюу 100.0% | | **70** |
| | | Тодорхой үр дүнд хүрсэн буюу | 90.0% | **7** |
| | | | 70.0% | **16** |
| | | Эрчимжүүлэх шаардлагатай буюу | 50.0% | **1** |
| | | | 30.0% | **9** |
| | | Үр дүнгүй буюу 0% | 0% | **3** |
| | | Үнэлэх боломжгүй/ хугацаа болоогүй | | **2** |
| **Хэрэгжилтийн дундаж хувь, оноо** | | | | **86.58% буюу 4.32 оноо** |

ТАНИЛЦСАН:
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Б.АЗЖАРГАЛ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА П.БАЯРСАЙХАН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.МӨНХСҮРЭН

## ДАРХАН-УУЛ АЙМГИЙГ 2024 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2024.12.13

### Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

"Дархан-Уул аймгийг 2024 онд хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөө"-ний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, гарсан дүгнэлт зөвлөмжийг 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөлтөд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

### Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэслэл, арга зүй

Засгийн газрын 2021 оны 374 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс нэгтгэж ирүүлсэн "Дархан-Уул аймгийг 2024 онд хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт"-ийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэхдээ "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6 дугаар бүлгийн 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу арга хэмжээний хүрсэн түвшинг хүрэх түвшинд харьцуулан хувиар, зорилтын хэрэгжилтийг энэ журмын 6.2.3-т заасан аргачлалын дагуу тооцож, арга хэмжээний дундаж үнэлгээгээр 4 ангилалд шилжүүлэн тооцлоо.

### Гурав. Дүгнэлт

"Дархан-Уул аймгийг 2024 онд хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөө"-ний нийт 17 салбарын хүрээнд **108** арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд ерөнхий үнэлгээ арга хэмжээгээр **"Тодорхой үр дүнд хүрсэн"** буюу **86.58%**-иар үнэлэгдлээ.

- "Үр дүнтэй" буюу 100% үнэлгээтэй 70 арга хэмжээ,
- "Тодорхой үр дүнд хүрсэн" буюу 90-70% үнэлгээтэй 23 арга хэмжээ,
- "Эрчимжүүлэх шаардлагатай" буюу 30-50% үнэлгээтэй 10 арга хэмжээ
- "Үр дүнгүй буюу 0% 3 арга хэмжээ,
- "Хугацаа болоогүй, үнэлэх боломжгүй" 2 арга хэмжээ байна.

*Журмын 6 дугаар бүлгийн 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу* ***арга хэмжээний хүрсэн түвшинг хүрэх түвшинд харьцуулан хувиар илэрхийлбэл:***

| № | Хяналтад авсан бодлого / Арга хэмжээний үнэлгээ | | | Бүгд |
|---|---|---|---|---|
| 1. | Хяналтанд авсан салбарын тоо | | | **17** |
| 2. | Хяналтанд авсан төсөл, арга хэмжээний тоо | | | **108** |
| 3. | Үнээс | Үр дүнтэй буюу 100.0% | | **70** |
| | | Тодорхой үр дүнд хүрсэн буюу | 90.0% | **7** |
| | | | 70.0% | **16** |
| | | Эрчимжүүлэх шаардлагатай буюу | 50.0% | **1** |
| | | | 30.0% | **9** |
| | | Үр дүнгүй буюу 0% | 0% | **3** |
| | | Үнэлэх боломжгүй/ хугацаа болоогүй | | **2** |
| **Хэрэгжилтийн дундаж хувь, оноо** | | | | **86.58% буюу 4.32 оноо** |

**0-50%-ийн үнэлгээтэй 13, хугацаа болоогүй 1, үнэлэх боломжгүй 1** арга хэмжээнүүдийг дэлгэрэнгүй танилцуулбал:

| № | Бодлогын үндэслэл | Зорилт, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч | Эх үүсвэр | Суурь түвшин | Хүрэх түвшин | Зарцуулсан төсөв | Хүрсэн түвшин | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | ЗДҮАХХАХТ-1.1.2.5 | Нэгдсэн эмнэлгийн маммаграфи аппарат | АЗДТГ, НЭ, | УТХО | 0 | 1 | 4,000.0 | Нэгдсэн эмнэлгийн ангиографийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын тендер сонгон шалгаруулалтыг 2024 оны 1-р сарын 18-наас эхлэн зарласан ч гүйцэтгэгч тодроогүй байна. 7 удаа тус тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтод Монополын эсрэг газрын шаардлагын дагуу өөрчлөлт оруулсан. **Үр дүн: Ангиографийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэнээр зүрхний шигдээс өвчнийг орон нутагт эмчлэх, нарийн мэргэжлийн хагалгааг хийх боломж бүрдэнэ.** | 30% |
| 27 | ЗДҮАХХАХТ-1.3.2.2 | Сургуулийн барилгын өргөтгөл, 960 суудал /Дархан сум 10-р баг ОИЦ сургууль/ | АЗДТГ, БШУГ | УТХО | 0 | 30% | 19,635.0 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дархан сумын 10-р баг ОИЦ сургуулийн 960 суудалтай сургуулийн барилга, төсөвт өртөг 19.6 тэрбум төгрөг батлагдсан. Төрийн худалдан авах ажиллагааны газар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил зохион байгуулагдаж 2024 оны 12 дугаар сард гэрээ байгуулсан. Тус төсөл нь 2024-2026 онд бүрэн хэрэгжиж дуусна. **Үр дүн: 960 суудалтай сургуулийн барилга баригдсанаар ОИЦ-ын ачаалал буурч анги дүүргэлт стандарт хэмжээнд хүрнэ.** | 30% |
| 28 | ЗДҮАХХАХТ-1.3.2.2 | Сургуулийн барилга 1500 суудал /Дархан-Уул, Дархан сум/ | АЗДТГ, БШУГ | УТХО | 0 | 30% | 24,976.0 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дархан сумын 14-р баг 1500 суудалтай сургуулийн барилга, төсөвт өртөг 24.9 тэрбум төгрөг батлагдсан. Гүйцэтгэгчээр "Болд" ХХК шалгарч ажлын гүйцэтгэл 10% гүйцэтгэлтэй байна. Тус төсөл нь 2024-2026 онд бүрэн хэрэгжиж дуусна. **Үр дүн: Дархан сумын 14-р багт 1500 суудалтай сургууль баригдсанаар Од цогцолбор** | 30% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | **сургуулийн А, Б байрны ачаалал буурна.** | |
| 32 | ЗДҮА ХХАХ Т-1.4.1.5 | Хөдөө аж ахуйн салбарын их, дээд сургуулиудыг өргөжүүлэхийг бодлогоор дэмжинэ. | АЗДТГ, ХААИС | | | | | Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан ажлын хүрээнд Хөдөө аж ахуйн яам Дархан-Уул аймагт шилжин ажиллаж байна. Төвийн бүсэд Хөдөө аж ахуйн их сургуулийн нэгдсэн хотхон байгуулахаар талаар улсын дунд хугацааны бодлогын бичиг баримтад туссан. **Үр дүн: Монгол Улсын Застийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан.** | 30% |
| 55 | ЗДҮА ХХАХ Т-2.7.1.2 | Орхон, Хонгор сумдын төвийн Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг үе шаттай хангах | АЗДТГ, ГХБХБГ | Сумдын ОНХСан | 2 | 4 | 100.0 | Дархан-Уул аймгийн Хонгор, Орхон сумын Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгаврыг боловсруулан Газар зохион байгуулалт геодези зураг зүйн ерөнхий газартай зөвшилцөж, аймгийн Засаг даргаар батлуулан сумдын Тамгын газар хүргүүлсэн. Батлагдсан даалгаврын дагуу 2024 оны эхний хагас жилд тендер зарласан ч аж ахуй нэгж байгууллага оролцоогүй. Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийлгэх төсвийг 2025 оны сумдын орон нутгийн төсөвт тусгаж хамтран ажиллахыг сумын ИТХ, Сумын Засаг дарга нарт 2024.11.15-ны өдрийн 677, 678 тоот албан бичгээр хүргүүлсэн. **Үр дүн: Хонгор, Орхон сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгавар боловсруулагдсан.** | 30% |
| 76 | ЗДҮА ХХАХ Т-3.1.1.5 | Аймгийн төвд байрлах "Залуучууд театр"-н Лэд дэлгэцээр иргэдэд мэдээлэл түгээх | МТА | ОНТ | 0% | 100% | 10.6 | 2024 онд Зөөврийн лед дэлгэцийг нийт 81 удаагийн арга хэмжээнд угсарч ажиллуулсан. Лэд дэлгэцийн дагалдах хэрэгсэлд /хайрцаг, дугуй гэх мэт/ урсгал засвар үйлчилгээг хийсэн. 2024 оны жилийн эцсийн байдлаар Залуучууд театрын гаднах лед дэлгэц гэмтэл гарч ажиллахгүй байна. **Үр дүн: 81 удаа мэдээ мэдээллийг олон нийтэд түгээсэн.** | 0 |
| 80 | ЗДҮА ХХАХ Т- | Галт түймэр унтраах 54 дүгээр анги, 8 дугаар цэцэрлэгийг төвийн төвлөрсөн шугамд холбоно | ОБГ | ОНТ | 0 | 2 | 800.0 | 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр аймгийн ИТХ-ын хуралдаанаар төсөвт тодотгол хийсэнтэй холбогдуулан Дархан сумын 1-р багт байрших ОБГ-ын 54-р анги, 8-р цэцэрлэгийн төвлөрсөн дулаан хангамжид холбох ажилд 832.0 сая төгрөг батлагдсан. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил хийгдэж байна. **Үр дүн: Төвлөрсөн дулаан хангамжид ОБГ 54-р анги, 8-р цэцэрлэг холбогдоно.** | 30% |
| 91 | ЗДҮА ХХАХ Т-4.1.1.1 | Хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсэд хамгаалалтын хайс барьж тохижуулах | БОАЖГ, СДОА | БОХН САХЗ | 0 | 3 | 24.0 | Дархан хотын хүн амын ус хангамжийн төв өндрийн цамхгийг ариутгах ажлыг Дархан Ус суваг ХК хийж гүйцэтгэсэн. Үндны усны эх үүсвэрийг хайс барьж тохижуулах ажлын зураг төсөв боловсруулагдсан. Нийт төсөвт өртөг 1.9 тэрбум төгрөг. Хөрөнгийн эх үүсвэрийг 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэхээр саналыг Барилга хот байгуулалтын яаманд цахим систем /PIMIS/ хүргүүлсэн. **Үр дүн: Хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсэд хамгаалалтын хайс барьж тохижуулах ажлын зураг, төсөв боловсруулагдсан.** | 30% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 92 | ЗДҮА ХХАХ Т-4.1.1.1 | Гадаргын усны чанарын шинжилгээний болон хэмжилтийн явуулын багаж, тоног төхөөрөмж авах | БОАЖГ, СДОА | БОХН САХЗ | 0 | 4 | 10.0 | Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. | 0% |
| 100 | ЗДҮА ХХАХ Т-5.1.1.1 | Хар металлургийн үйлдвэрийн цогцолбор, Барилга, барилгын материалын үйлдвэрийн цогцолбор, Дархан арьс ширний үйлдвэрийн цогцолбор, Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ. | АЗДТГ, ХБТХОХ, ХХААГ | Бусад | | | | 1. Дархан арьс ширний цогцолбор ХХК үйлдвэрийг байгуулснаар 7500 орчим байнгын ажлын байр, жилдээ 10 сая.ш арьс шир боловсруулах 13 үйлдвэр, 10 мян.тн ноос боловсруулах ноос, ноолуур угаах самнах үйлдвэр, түүний цэвэрлэх байгууламж, инженерийн дэд бүтцийн барилга байгууламж бий болох бөгөөд 2024 оныг хүртэл төслийн нийт төсөвт өртгийн 47.4 хувийг гүйцэтгэсэн. "Дархан Арьс Ширний Цогцолборын бүтээн байгуулалт" ТӨХК-д орон нутгаас арьс ширний цогцолбор барих ажилд 25 га талбайг шийдвэрлэсэн. 2. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчээр 60 аж ахуйн нэгж, 23 иргэн бүртгэлтэй байна. Салбараар нийт 97 үйлдвэр, цех үйл ажиллагаа явуулж байна. Хүнсний хувьсгалын хүрээнд арилжааны банкаар дамжуулан олгосон эргэлтийн болон хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээлд 2023 онд 44.52 тэрбум төгрөг, 2024 онд 1 мал төхөөрөх үйлдвэрт 3.0 тэрбум төгрөгийн, ЖДҮХС-ийн зээлээс 2023 онд 6 аж ахуйн нэгжид 716 сая төгрөг, 2024 онд 9 аж ахуйн нэгжид 1.42 тэрбум төгрөгийн дэмжлэг тус тус үзүүлсэн. Хөнгөлөлттэй зээлд хамруулснаар ажлын байр, агуулахыг стандартад нийцүүлж, техник, технологийн шинэчлэл хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлж өгсөн. **Үр дүн: Хүнсний боловсруулах үйлдвэрт 1129 хүн тогтвортой ажиллаж байна.** | 50% |
| 102 | ЗДҮА ХХАХ Т-5.1.2.1 | Дархан сумын 5 дугаар багийн гэр хорооллыг хувийн орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ. | АЗДТГ, "ДДТ" ОНӨААТҮГ | Бусад | 0 | 35 | 0.0 | 1. Дархан дахин төлөвлөлт ОНӨААТҮГ нь Дархан-Уул аймагт хэрэгжиж буй Европын хотуудын холбооны санхүүжилттэй Найрамдал төслийн хүрээнд Дархан сумын 5 дугаар багийн гэр хорооллын нутаг дэвсгэрт хийгдсэн гадна инженерийн шугам сүлжээнээс хэрэглэгчийг холбох 2 дугаар хэлхээний шугам сүлжээний зургийг нэгдсэн байдлаар хийж гүйцэтгэсэн. Тус байршилд 289 айл өрхийн шугам сүлжээний зураг төсөв хийгдсэн. **Үр дүн: Гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн дэд бүтцэд холбох ажлын зураг, төсөв боловсруулагдсан.** | 30% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 103 | ЗДҮА ХХАХ Т-5.1.2.3 | Дархан сумын 7 дугаар багийн зарим хэсэг, 8 дугаар багийн гэр хорооллыг хувийн орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ. | АЗДТГ, "ДДТ" ОНӨААТҮГ | Бусад | 25 | 45 | 624.0 | 1. Дархан дахин төлөвлөлт ОНӨААТҮГ нь Дархан-Уул аймагт хэрэгжиж буй Европын хотуудын холбооны санхүүжилттэй Найрамдал төслийн хүрээнд Дархан сумын 8 дугаар багийн Нарантолгой, Манхантолгой гэр хорооллын нутаг дэвсгэрт хийгдсэн гадна инженерийн шугам сүлжээнээс хэрэглэгчийг холбох 2 дугаар хэлхээний шугам сүлжээний зургийг нэгдсэн байдлаар хийж гүйцэтгэсэн. Тус байршилд 298 айл өрхийн шугам сүлжээний зураг төсөв хийгдсэн. 2. Дархан сумын Манхантолгой хэсгийн 38 айл өрхийн дулааны техникийн нөхцөлийн хүсэлтийг нэгтгэж Дархан дулааны сүлжээ ТӨХК-р хэлэлцүүлэн 35 айлд дулааны техникийн нөхцөлийг гаргуулах ажлыг зохион байгуулсан.<br>3. 2024 оны Эдийн засаг, хөгжлийн сайдын А/12 дугаар тушаалаар батлагдсан Дархан сумын 1,3,5,6,7,8,9,14,15 дугаар багийн гэр хорооллын нутаг дэвсгэрт хийгдэж буй Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байна.<br>**Үр дүн: Дархан сумын 1, 3, 5, 6, 7, 8, 9, 14, 15 дугаар багийн гэр хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдаж байна.** | 30% |
| 105 | ЗДҮА ХХАХ Т-5.1.3.2 | Арьс ширний цогцолборын бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлнэ. | ДҮТП, ХОХБТХ, ХХААГ | Бусад | | | | 1.Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй "Дархан арьс ширний цогцолбор ХХК" үйлдвэрийн эрчим хүч, усан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламж, дулаан хангамж, уурын зуух зэргийг барьж байгуулахад 15.4 сая ам долларын хөрөнгө оруулалтыг хийж, эрчим хүч 95%, дэд станц ажил гүйцэтгэл 90%, ус, дулаан хангамж 70%, бохир ус цэвэрлэх байгууламжийн аэро-танк зэрэг ажлууд хийгдсэн. Төслийн нийт төсөвт өртөг нь 86.2 тэрбум төгрөг үүнээс 40.8 тэрбум төгрөгийн ажил хийгдэж 47.4 хувийн гүйцэтгэлтэй ажиллажээ. 2024 онд Дархан-Уул аймгийн Засаг дарга Б.Азжаргал, ХХААХҮЯ-ны сайд Ж.Энхбаяр болон "Дархан арьс ширний цогцолбор" ХХК-ий гүйцэтгэх захирал Д.Энхбаяр болон холбогдох албаны төлөөлөлтэй уулзаж, хувийн хэвшлийн тулгамдаж буй асуудлыг сонсож, цаашид үйл ажиллагааг нь эрчимжүүлэх тал дээр санал солилцсон.<br>2.Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссаны дагуу 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн Засгийн газрын 185 дугаар тогтоолоор "Дархан арьс ширний цогцолбор" төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил, эзэмшил, ашиглалтыг хариуцах "Дархан Арьс Ширний Цогцолборын бүтээн байгуулалт" ТӨХК-г байгуулагдсан. Орон нутгаас арьс ширний цогцолбор барих ажилд 25 га талбайг шийдвэрлэсэн.<br>**Үр дүн: Орон нутгаас бодлогоор дэмжин газар олголтыг шийдвэрлэсэн.** | 0% |

| № | Бодлогын үндэслэл | Зорилт, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч | Эх үүсвэр | Суурь түвшин | Хүрэх түвшин | Зарцуулсан төсөв | Хүрсэн түвшин | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 84 | ЗДЗАХХАХТ-3.4.1.3 | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 80 хувьд хүргэнэ. | АЗДТГ, ХЭЗХ | ОНТ | 50% | 80% | 2.0 | Дархан-Уул аймгийн 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулж 3 зорилтын 20 арга хэмжээг http://khutulbur.iaac.mn/ цахим санд бүртгэж 2024 оны эхний хагас жилийн үнэлгээгээр 68.67%-иар үнэлэгдээд байна. 2024 оны жилийн эцсийн тайланг үнэлэх хугацаа болоогүй байна. **Үр дүн: 2024 оны эхний хагас жилийн үнэлгээгээр 68.67%-иар үнэлэгдээд байна.** | ХБ |
| 104 | ЗДҮАХХАХТ-5.1.3.1 | Паркийн гишүүн аж ахуйн нэгжийг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжих | ДҮТП, ХОХБТХ | ОНТ Найрамдал төсөл | | 10 | 200.0 | 2021 онд Австри улсын Засгийн газрын 1 сая еврогийн санхүүжилтээр аймгийн гэр хорооллын гудамж талбайд сүүлийн үеийн лед гэрэлтүүлэг шинээр суурилуулах ажлыг Дархан сумын 1, 2, 3, 5, 6, 7, 8, 13, 15 дугаар баг, Хонгор, Орхон, Шарын гол сумдад нийт 1,408.0 ширхэг гэрэлтүүлэг шинээр суурилуулах ажил хийгдсэн. Азийн Хөгжлийн Банкны хөнгөлөлттэй зээлээр "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хөгжлийн төв"-ийг Дархан сумын 12 дугаар багт шинээр байгуулсан. 2022 онд Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламж "Өвсний үндэс" төслийн хүрээнд Дархан сумын "Энэрэл" сургуулийн барилгын их засварын ажлыг 600.0 сая төгрөгөөр, Дархан сумын 5-р баг 15-р сургуулийн барилгын 00 засвар, 12-р сургуулийн 00 засварын ажлыг 300.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн бол Дархан сумын 15-р багт 960 хүүхдийн сургуулийн барилгыг Азийн хөгжлийн банкны хөнгөлттэй зээлийн хөрөнгөөр 10.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдаж байна. 2023 онд Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг иргэд олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд цахим орчинд болон иргэд олон нийтэд 3 удаагийн уулзалтыг 4 сумын хэмжээнд /бүх сумдад/ зохион байгуулсан. Аймгийн ИТХ-ын хуралдаанд 2023 оны 4, 7-р сард аймаг орон нутагт хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээг танилцуулж, мэдээллээр хангаж ажиллаа. Хөрөнгө оруулалтын чуулга уулзалтыг 2023 оны 7-р сард Найрамдал төсөлтэй хамтран зохион байгуулсан. **Үр дүн: Гадаадын зээл тусламжаар 2021-2024 онд нийт 22.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн.** | ҮБ |

Дээрх 15 арга хэмжээний хувьд:

- Санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй 55, 91, 92 дугаар арга хэмжээнүүд байна.
- Санхүүжилт нь шийдэгдсэн, 2025-2026 он дамжин хэрэгжих боломжтой 27, 28, 80 дугаар арга хэмжээнүүд байна.
- Засгийн газрын гишүүд, төрийн захиргааны төв байгууллагын хамтын ажиллагааны түвшинд хэрэгжих боломжтой 32, 100, 105 дугаар арга хэмжээнүүд байна.
- Орон нутгийн түвшинд удирдлага, зохион байгуулалт, урт хугацаандаа хэрэгжих боломжтой 15, 76, 102, 103 дугаар арга хэмжээнүүд байна.
- Арга хэмжээ 84 буюу "Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийг үнэлэх хугацаа болоогүй байна.

- Арга хэмжээ 104-ийн хувьд үйлдвэр технологийн паркийн гишүүн аж ахуйн нэгж нь тодорхойгүй, хангалттай мэдээлэл байхгүй байх тул “үнэлэх боломжгүй” гэж үзлээ.

***Дөрөв. Цаашид анхаарах асуудал (Зөвлөмж)***

Сайн тал:

2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилттэй харьцуулахад суурь түвшин, шалгуур үзүүлэлтийг тусгасан. Хүрэх түвшинтэй уялдуулан тайлагнаж 2023 оны зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Анхаарах зүйл:

Дархан-Уул аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан аймгийн хөгжлийн жилийн 2025 оны төлөвлөгөөг боловсруулж,

2024 онд санхүүжилт нь шийдэгдсэн, он дамжин хэрэгжих арга хэмжээнүүдийг тусган хэрэгжүүлэх зөвлөмж, чиглэлийг өгч байна.

ТАНИЛЦСАН:
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Б.АЗЖАРГАЛ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА П.БАЯРСАЙХАН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Ө.МӨНХСҮРЭН